**"УЛААНБААТАР БҮК" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2018.03.14 №2018/..07 Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ**

"Компанийн тухай" хуулийн 60 дугаар зүйл, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 9/3202 тоот албан даалгавар болон Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 244 дүгээр тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэх, хяналт тавих журам"-ыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. "Улаанбаатар БҮК"ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2018 оны 4-р сарын 25-ны өдрийн 11.00 цагт Баянгол дүүргийн 20-р хороо, Дунд голын эрэгт байрлах компанийн өөрийн байранд хуралдуулсугай.

2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дор дурьдсан асуудлыг хэлэлцүүлэхээр батлалсугай.Үүнд:

   2.1. 2017 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

   2.2.Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;

   2.3."Улаанбаатар БҮК"ХК-ийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн талаар танилцуулах

   2.4.Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох;

   2.5.Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2018 оны төсөв батлах тухай;

3. Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу "Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл"-ийг Хавсралт №1-ээр баталж, 2018 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн дотор багтаан Санхүүгийн зохицуулах хороо болон "Монголын хөрөнгийн бирж"-д хүргүүлэх, "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар"-ыг Хавсралт №2-оор баталж 2018 оны 3 дугаар сарын 19-ний өдөр "Монголын хөрөнгийн бирж" болон өөрийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонингоор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд

*Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 3.. сарын өдрийн .....тоот тогтоолын Хавсралт №3*

"Улаанбаатар БҮК"ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комисс буюу Тооллогын комисс:

| | |
|---|---|
| Комиссын дарга: | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга-Д.Байгальмаа |
| Гишүүд: | Хуульч Д.Уянга<br>Мэдээллийн технологийн мэргэжилтэн Ц.Даваасүрэн<br>Нягтлан бодогч Р.Энх-Амгалан |

*Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 14-ны өдрийн 2018/07 тоот тогтоолын Хавсралт № 4*

**“УЛААНБААТАР БҮК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 11.00 цагт Баянгол дүүргийн 20-р хороо, Дунд голын эрэгт байрлах компанийн өөрийн байранд хуралдана.

**Хувьцаа эзэмшигч /эсхүл төлөөлөх этгээд/-ийн эцгийн нэр, өөрийн нэр:____________**
**Итгэмжлэлийн дагуу төлөөлж байгаа бол хэнийг, эсхүл ямар хуулийн этгээдийг төлөөлж буй хэн болох тухай тайлбар: ___________________________________**
**Регистрийн дугаар: ____________________________**
**Гэрийн хаяг, утасны дугаар, цахим хаяг: __________________________________________**
______________________________________________________________________________________
**Эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо ширхэг: энгийн, _______________________**
**Саналын эрхтэй хувьцааны тоо: _______________________**
**Саналын өгөх арга: энгийн**

| Хэлэлцэн шийдвэрлэх асуудал | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|---|---|---|---|
| 1.2017 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах | | | |
| 2. ТУЗ-ийн 2018 оны төсөв батлах | | | |

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг: _________________________/ /
2018 оны …….. сарын ……..-ний өдөр

Саналын хуудсыг хүчинтэй/хүчингүйд тооцон тоолсон:
Хүчингүйд тооцсон бол шалтгаан нь: ........................................................................................

Комиссын дарга:.............................. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга-Д.Байгальмаа

Гишүүд: ............................... Мэдээллийн технологийн мэргэжилтэн Ц.Даваасүрэн
Нягтлан бодогч Р.Энх-Амгалан

*Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 3-р сарын 14-ны өдрийн 2018/07 тоот тогтоолын Хавсралт № 5*

## "УЛААНБААТАР БҮК" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 11.00 цагт Баянгол дүүргийн 20-р хороо, Дунд голын эрэгт байрлах компанийн өөрийн байранд хуралдана.

**Хувьцаа эзэмшигч /эсхүл төлөөлөх этгээд/-ийн эцгийн нэр, өөрийн нэр:____________**
**Итгэмжлэлийн дагуу төлөөлж байгаа бол хэнийг, эсхүл ямар хуулийн этгээдийг төлөөлж буй хэн болох тухай тайлбар: ___________________________________**
**Регистрийн дугаар: ___________________________**
**Гэрийн хаяг, утасны дугаар, цахим хаяг: ________________________________________**
**_______________________________________________________________________________**
**Эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо ширхэг: энгийн, _______________________**
**Саналын эрхтэй хувьцааны тоо: _______________________**
**Саналын өгөх арга: кумулятив**

| Хэлэлцэн шийдвэрлэх асуудал | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|---|---|---|---|
| 1. ТУЗ-ийн гишүүдийг сонгох<br>ЕРДИЙН гишүүнээр:<br>1.<br>2.<br>3.<br>4.<br>5.<br>6.<br><br>ХАРААТ БУС гишүүнээр<br>1.<br>2.<br>3. | | | |

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг: _________________________/ /
2018 оны …….. сарын ……...-ний өдөр

Саналын хуудсыг хүчинтэй/хүчингүйд тооцон тоолсон:
Хүчингүйд тооцсон бол шалтгаан нь: ..........................................................................................
Тооллогын комиссын дарга:.................................. / /
Гишүүд: ...................................................................... / /
...................................................................... / /

ТУЗ-ийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар сонгоно. Энэ аргаар саналын тоог тогтоохдоо таны эзэмшиж буй хувьцааны тоог 9-өөр үржүүлнэ. Та ингэж тооцсон саналынхаа 2/3-ыг энгийн гишүүнд, 1/3-ыг хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд өгнө. .Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 6 нь ердийн, 3 нь хараат бус гишүүн байхаар дүрэмд заасан учраас та 900 саналынхаа /100*9гишүүн=900/ 600-г ердийн гишүүнд нэр дэвшигчдэд, 300-г хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд дурын хувилбараар хуваах, тухайн нэр дэвшигчид өгч буй саналынхаа тоог тэмдэглэнэ. Таны өгсөн нийт **саналын тоо 900-аас илүү юмуу дутуу байж болохгүй.**

*Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 3. сарын өдрийн .....тоот тогтоолын Хавсралт № 6* 14 2018/03

## "УЛААНБААТАР БҮК"ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 11.00 цагт Баянгол дүүргийн 20-р хороо, Дунд голын эрэгт байрлах компанийн өөрийн байранд хуралдана.

| № | Хэлэлцэх асуудал | Шийдвэрийн төрөл | Хугацаа | Хариуцах эзэн |
|---|---|---|---|---|
| 1 | Бүртгэлийн үйл ажиллагаа<br>-Хурлын ирцийг бүртгэх<br>-Ирцийг мэдээлэх | Тооллогын комиссын тогтоол | 10.30-11.00 | Тооллогын комисс |
| 2. | Хурлын нээлт<br>-Хурлыг нээх<br>-Хурлын дэг батлах | | 11.00-11.10 | Хурлын дарга |
| 3 | Хэлэлцэх асуудал-1: 2017 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;<br>-Асуулт хариулт<br>-Санал хураалт | ХЭХ-ын тогтоол | 11.10-11.50<br><br>11.50-12.00 | Гүйцэтгэх Захирал Б.Жамбал<br><br>Тооллогын комисс |
| 4 | Хэлэлцэх асуудал-2: Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;<br>-Асуулт хариулт | | 12.00-12.15 | Хурлын дарга |
| 5 | Хэлэлцэх асуудал-3: ."Улаанбаатар БҮК"ХК-ийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилт түвшингийн талаар танилцуулах;<br>-Асуулт хариулт | | 12.15-13.00 | Гүйцэтгэх Захирал Б.Жамбал |
| 6 | Цайны завсарлага | | 13.00-13.30 | Зохион байгуулах комисс |
| 7 | Хэлэлцэх асуудал-4: Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох;<br>-Асуулт хариулт<br>-Санал хураалт | ХЭХ-ын тогтоол | 13.30-14.00<br><br>14.00-14.20 | Хурлын дарга<br><br>Тооллогын комисс |
| 8 | Хэлэлцэх асуудал-5: Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2018 оны төсөв батлах тухай<br>-Асуулт хариулт<br>-Санал хураалт | ХЭХ-ын тогтоол | 14.20-14.50<br><br>14.50-15.00 | Хурлын дарга<br><br>Тооллогын комисс |
| 9 | Шийдвэр гаргах: | Тооллогын комиссын | 15.00-15.20 | Хурлын дарга |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | -Хэлэлцэх асуудал 1-ийн санал хураалтын дүн, шийдвэр танилцуулах<br><br>-Хэлэлцэх асуудал 4-ийн санал хураалтын дүн, шийдвэр танилцуулах<br><br>-Хэлэлцэх асуудал 5-ийн санал хураалтын дүн, шийдвэр танилцуулах | Тогтоол | | Тооллогын комисс |
| 11 | Хурал хаах | | 15.20-15.30 | Хурлын дарга |

мэдээлэх, мөн уг зарыг 2018 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр анх мэдээлсний дагуу дахин хурлын зар хүргэхээр тогтсугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2018 оны 3 дугаар сарын 23-ны дотор багтаан хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер диллерийн компанид хүргүүлсүгэй.

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2017 оны 4-р сарын 3-ний өдрөөр тогтоосугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг хавсралт №6-ийн дагуу баталж, дэгийн дагуу хурлыг удирдан зохион байгуулахыг ТУЗ-ийн дарга Д.Нямхүүд даалгасугай.
7. Хурлын бэлтгэл ажил зохион байгуулах болон Тооллогын комиссыг Хавсралт №3-аар томилсугай.

8. Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу саналын хуудсыг Хавсралт №4, 5-аар тус тус баталсугай.

9. Хурлын бэлтгэл ажлыг зохих журмын дагуу бүрэн хангаж, хурлыг заасан хугацаанд хууль, журамд нийцүүлэн зохион байгуулахыг Хурлын бэлтгэл ажил зохион байгуулах комисст/дарга Д.Байгалмаа-д/даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Д.НЯМХҮҮ

Улаанбаатар хот Бариlга Үйлдвэрлэлийн ★ Улаанбаатар БҮК ХК ТТА3520 2041219

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 3 сарын 14 өдрийн 2017/07 тоот тогтоолын Хавсралт №1

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

| | |
|---|---|
| Компанийн нэр | "Улаанбаатар БҮК"ХК |
| Хаяг, утас | Баянгол дүүргийн 20-р хороо, Дунд голын эрэгт байрлах компанийн өөрийн байр. Утас: 70001182, 88079542 |
| Хурал хуралдах огноо, цаг | 2018 оны 4-р сарын 25-ны өдрийн 11.00 цагт |
| Хурал хуралдах газар /хаяг, байршил/ | Баянгол дүүргийн 20-р хороо, Дунд голын эрэгт байрлах компанийн өөрийн байранд |
| Хурлын төрөл | Ээлжит |
| Хурал зарлагч | Төлөөлөн удирдөх зөвлөл |
| Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо | 2018 оны 3 дугаар сарын 14-ны өдөр |
| Олон нийтэд зарлах огноо | 2018 оны 3 дугаар сарын 19-ний өдөр<br>2018 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр |
| Бүртгэлийн өдөр | 2017 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр |
| Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх огноо | 2017 оны 3 дугаар сарын 23-ны өдөр |
| Хүргүүлсэн огноо | 2017 оны 3 дугаар сарын 19-ний өдөр |
| Хурлын даргын нэр | Д.Нямхүү |
| Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр | Комиссын дарга:ТУЗ-ийн нарийн бичгийн дарга-Д.Байгалмаа<br>Гишүүд: Хуульч Д.Уянга<br>Мэдээллийн технологийн мэргэжилтэн Ц.Даваасүрэн<br>Нягтлан бодогч Р.Энх-Амгалан |
| Баримт бичгийн жагсаалт, бэлэн болгох эцсийн хугацаа | • Хурал хуралдуулах шийдвэр<br>• Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх зарын загвар<br>• Саналын хуудасны загварууд<br>• Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт, бэлэн болгох эцсийн хугацаа<br>• Хурлын дэг<br>• Баримт бичгийг бэлэн болгох эцсийн хугацаа: 2018 оны 3-р сарын 23 |
| Баримт бичгийн хуудасны тоо | |

*Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 3 сарын 14 өдрийн 20/18/07 тоот тогтоолын Хавсралт №2*

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ХҮРГЭХ ЗАР**

**“УЛААНБААТАР БҮК” ХК -ИЙН**
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

“Улаанбаатар БҮК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 4-р сарын 02-ны өдрийн 11.00 цагт Баянгол дүүргийн 20-р хороо, Дунд голын эрэгт байрлах өөрийн компанийн байранд болно. Хурлаар доорхи асуудлуудыг хэлэлцэнэ. Үүнд:

1. 2017 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

2. Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;

3. ”Улаанбаатар БҮК”ХК-ийн 2018 оны .”Улаанбаатар БҮК”ХК-ийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн талаар танилцуулах

4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг, чөлөөлөх, томилох ;

5. Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2018 оны төсөв батлах тухай;

**Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах Бүртгэлийн өдөр: 2018.4.03**

Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдөр, журам:

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2018 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 9.30-17.30 цагийн хооронд 70001182, 88079542 утсаар болон Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Дунд голын эрэгт байрлах “Улаанбаатар БҮК” ХК-ийн байранд ирж ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай уулзан танилцаж болно.Эсвэл Компанийн вебсайт болох www.ubbuk.mn-ийн хаягаар орж танилцаж болно.

Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:

1. Хувьцаа эзэмшигчдийнээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх “саналын хуудас”
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт

4.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл

Хурал зохион байгуулах комисс:
Утас: 70001182, 88079542, .
E-mail: law@ubbuk.mn, ubbuk2@yahoo.com